



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2008 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

“Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.11, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.7, 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**МОНГОЛ УЛСАД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРАА НЭЭХ, ТҮҮГЭЭР  
ДАМЖУУЛАН ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ГАДААДЫН  
ДААТГАГЧ, МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ  
НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)- ноос гадаадын даатгалын компани (цаашид “гадаадын даатгагч” гэх)-д Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч компани (цаашид “гадаадын мэргэжлийн оролцогч” гэх)-д Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) олгох, гадаадын даатгагчийн салбар компани (цаашид “гадаадын даатгагчийн салбар” гэх)-ийн болон гадаадын мэргэжлийн оролцогчийн салбар компани (цаашид “гадаадын мэргэжлийн оролцогчийн салбар” гэх)-ийн дүрмийн сангийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсад гадаадын даатгагчийн салбарыг нээхэд Даатгалын тухай хууль, Компанийн тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийг байгуулна.

1.3. Монгол Улсад гадаадын мэргэжлийн оролцогчийн салбарыг нээхэд Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийг байгуулна.

1.4. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Хороо нь тусгай зөвшөөрөл олгохдоо гадаадын даатгагчийн салбарын болон гадаадын мэргэжлийн оролцогчийн салбарын дүрмийн сангийн өмчлөл, эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрээс үл хамааран Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, даатгалын багц дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлага, зарчмыг баримтална.

1.5. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр бусдад шилжүүлж үл болно.

**ХОЁР. Гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбар  
нээхэд тавигдах нөхцөл, шаардлага**

**А. Гадаадын даатгагчийн салбар**

2.1. Олон улсын санхүүгийн үнэлгээ, зэрэглэл тогтоох байгууллагаас гадаадын даатгагчийн авсан үнэлгээ, зэрэглэл нь “Standard and Poors”-ээс гаргасан “BBB” зэрэглэлтэй тэнцэх, эсхүл түүнээс дээш байх.

2.2. Гадаадын даатгагчийн салбар компанийн дүрмийн сангийн доод хэмжээ Даатгалын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байх.

2.3. Даатгалын үйл ажиллагааны 5-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөөтэй байх. Даатгалын зах зээлд нийлүүлэх 3-аас дээш бүтээгдэхүүнтэй байх.

2.4. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх.

2.5. Салбарын ажилтнуудын 70-аас доошгүй хувийг Монгол Улсын иргэдээс бүрдүүлсэн байх.

2.6. Даатгалын тухай хуулийн 20.10 болон Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан удирдах ажилтантай байх.

2.7. Гүйцэтгэх удирдлага нь гадаадын иргэн байх тохиолдолд монгол хэлээр ярьж, бичдэг байх, эсхүл орон тооны орчуулагчтай байх.

2.8. Хороо гадаадын даатгагчийн салбарын эрхлэх тухайн даатгалын ангилал, төрөл, хэлбэрээс хамааран шаардлагатай гэж үзсэн нэмэлт нөхцөл, шаардлага тавьж болно.

#### Б. Гадаадын мэргэжлийн оролцогчийн салбар

2.9. Олон улсын санхүүгийн үнэлгээ, зэрэглэл тогтоох байгууллагаас гадаадын даатгагчийн авсан үнэлгээ, зэрэглэл нь “Standard and Poors”-ээс гаргасан “BBB” зэрэглэлтэй тэнцэх, эсхүл түүнээс дээш байх.

2.10. Гадаадын мэргэжлийн оролцогчийн салбар компанийн дүрмийн сангийн доод хэмжээ 50,0 (тавин) сая төгрөг байх. Даатгалд жил бүр даатгуулах ба мэргэжлийн хариуцлагын даатгалын хэмжээний доод хязгаар 100,0 (нэг зуун) сая төгрөг байх.

2.11. Компанийн үйл ажиллагааны 5-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөөтэй байх. Даатгалын тухай хуулийн 6.1-д заасан ангилалын дагуу урт хугацааны даатгал, эсхүл ердийн даатгалын аль нэгийг эрхлэх. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх даатгалын хэлбэрээ тодорхойлсон байх. Давхар даатгалын, эсхүл ердийн болон урт хугацааны даатгалын гэрээний алинд зуучлах талаар чиглэлээ тодорхойлсон байх. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай судалгааны материалтай байх.

2.12. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх.

2.13. Салбарын ажилтан нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх, 3-аас доошгүй жилийн ажлын дадлага туршлагатай байх.

2.14. Салбарын ажилтнуудын 70-аас доошгүй хувийг Монгол Улсын иргэдээс бүрдүүлсэн байх.

2.15. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.8 болон Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан удирдах ажилтантай байх.

2.16.Гүйцэтгэх удирдлага нь гадаадын иргэн байх тохиолдолд монгол хэлээр ярьж, бичдэг байх, эсхүл орон тооны орчуулагчтай байх.

2.17.Хороо гадаадын мэргэжлийн оролцогчийн салбарын эрхлэх даатгалын мэргэжлийн оролцогчийн төрөл, даатгалын ангилал, төрөл, хэлбэрээс хамааран шаардлагатай гэж үзсэн нэмэлт нөхцөл, шаардлага тавьж болно.

**ГУРАВ. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчоос бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт**

А. Гадаадын даатгагчийн салбар

3.1.Гадаадын даатгагчийн салбар байгуулж, тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Даатгалын тухай хуулийн 19, энэ журмын 2-т тус тус заасны дагуу дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

3.1.1.Гадаадын даатгагчаас Монгол Улсад салбараа нээх талаар Хороонд хандаж ирүүлсэн албан бичгийн эх хувь;

3.1.2.Гадаадын даатгагчийн үйл ажиллагаа явуулдаг тухайн улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолт, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.3.Ердийн даатгал, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 1 дүгээр хавсралын дагуу, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг Хорооны 2007 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн журам”-ын 1 дүгээр хавсралтын дагуу тус тус гаргана;

3.1.4.Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт бүртгүүлсэн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.5.Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар (уг дүрмэнд компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэр, хөрөнгө оруулагчийн хурал, ТУЗ, Хяналтын зөвлөлийн ажиллах журам, эрх, үүрэг, хариуцлага, компанийн хувьцааг арилжих, бусдад шилжүүлэх, хязгаарлалт хийх үйл ажиллагааг тусгасан байх);

3.1.6.Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар хавсралтад дурдсан зөвлөмжийн дагуу боловсруулсан компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө;

3.1.7.Тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр боловсруулсан журам, даатгалын гэрээ, гэрээний баталгааны загвар (даатгалын гэрээ болон гэрээний баталгаанд Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд зааснаас гадна даатгалын нөхөн төлбөр олгох нөхцөл, түүнийг шийдвэрлэх хугацааг нэмж тусгасан байх);

3.1.8. Даатгалын тухай хуулийн 14.2.5, Хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-д заасны дагуу тооцоолол хийсэн хураамжийн хувь хэмжээний тооцоолол, танилцуулга;

3.1.9. Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар хавсралтын дагуу гаргасан гүйцэтгэх удирдлага болох бусад боловсон хүчний тодорхойлолт;

3.1.10. Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан техник тоног төхөөрөмж, програм хангамжийн жагсаалт, ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар;

3.1.11. Бусад баримт бичиг (Хороо шаардлагатай гэж үзвэл мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон эсэх тухай болон компанийн эрх бүхий албан тушаалтны ял шийтгэлтэй эсэх тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт, хэрэв гадаадын иргэн бол уг иргэний харьяалалтай улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг шаардаж болно).

#### Б. Гадаадын мэргэжлийн оролцогчийн салбар

3.2. Гадаадын мэргэжлийн оролцогчийн салбар байгуулж, тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 10, 13, энэ журмын 2-т тус тус заасны дагуу дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

3.2.1. Гадаадын мэргэжлийн оролцогчоос Монгол Улсад салбараа нээх талаар Хороонд хандаж ирүүлсэн албан бичгийн эх хувь;

3.2.2. Гадаадын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулдаг тухайн улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолт, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.2.3. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 1 дүгээр хавсралтын дагуу гаргана;

3.2.4. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт бүртгүүлсэн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.2.5. Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар (уг дүрмэнд компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэр, хөрөнгө оруулагчийн хурал, ТУЗ, Хяналтын зөвлөлийн ажиллах журам, эрх, үүрэг, хариуцлага, компанийн хувьцааг арилжих, бусдад шилжүүлэх, хязгаарлалт хийх үйл ажиллагааг тусгасан байх);

3.2.6. Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн

журам”-ын 5 дугаар хавсралтад дурдсан зөвлөмжийн дагуу боловсруулсан компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө;

3.2.7.Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар хавсралтын дагуу гаргасан гүйцэтгэх удирдлага болон бусад боловсон хүчний тодорхойлолт;

3.2.9.Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан техник тоног төхөөрөмж, програм хангамжийн жагсаалт, ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар;

3.2.10.Бусад баримт бичиг (Хороо шаардлагатай гэж үзвэл мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон эсэх тухай болон компанийн эрх бүхий албан тушаалтны ял шийтгэлтэй эсэх тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт, хэрэв гадаадын иргэн бол уг иргэний харьяалалтай улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг шаардаж болно).

**ДӨРӨВ. Гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчид салбараа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах**

4.1.Тусгай зөвшөөрөл олгохыг хүсч гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11, 12, Даатгалын тухай хуулийн 20.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.1, энэ журмыг үндэслэн хянаж, шаардлагатай баримт материалыг шалгаж баталгаажуулсны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгох тухай асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

4.2.Тусгай зөвшөөрөл олгох эсэхийг Хороо гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчоос ирүүлсэн өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш Даатгалын тухай хуулийн 20.7, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу ажлын 45 хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв бичиг баримтыг зайлшгүй магадлан шинжлэх, нэмж тодруулах шаардлагатай бол энэ хугацааг нэмэлт материалыг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

4.3.Тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэр гарсны дараа гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбар компанийн дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг Хорооны хяналтын дансанд түр байршуулах тухай мэдэгдлийг Хороо албан бичгээр өгнө.

4.4.Гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогч нь уг албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор өөрийн салбар компанийн дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг Хорооны хяналтын дансанд төвлөрүүлж, хуанлийн 10 хоногийн хугацаатай байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

4.5.Тусгай зөвшөөрөл олгох тухай Хорооны шийдвэрт гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн тухайн салбарт даатгалын ямар ангилал, төрөл, хэлбэрээр болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгосныг тусгана.

4.6.Тусгай зөвшөөрөл олгох тухай Хорооны шийдвэр болон Хорооноос баталсан “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд заасны дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн тухайн салбарт Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

4.7.Тусгай зөвшөөрөл олгогдсон гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбарын гүйцэтгэх удирдлага нь Хорооны хяналтын дансанд түр байршуулсан мөнгөн хөрөнгийг өөрийн харилцах дансанд шилжүүлж авах тухай хүсэлтээ Хороонд албан бичгээр гаргана.

4.8.Хороо нь гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбарт олгосон тусгай зөвшөөрлийг бүртгэн авч, зохих зааврын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

4.9.Хорооноос тусгай зөвшөөрөл авсан гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбар нь компанийн дүрэм, бусад баримт бичигт орсон өөрчлөлтийг Гадаадын хөрөнгө оруулалтын агентлаг, Улсын бүртгэлийн албанд бүртгүүлнэ.

4.10.Гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбар нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших хугацаанд тусгай зөвшөөрөл авахаар анх бүрдүүлж ирүүлсэн баримт бичигт өөрчлөлт орсон тухайн бүрт уг өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

4.11.Хороо дараах үндэслэлээр гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбарт тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

4.11.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;

4.11.2.Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон;

4.11.3.Гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогч нь олон улсын санхүүгийн зах зээлд гарсан гэмт хэрэгтэй холбогдож шийтгэгдсэн нь тогтоогдсон тухай мэдээлэл ирсэн;

4.11.4.Хорооноос гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийг мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон байж болохыг тогтоосон;

4.11.5.Бусад хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй.

4.12.Гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбарт тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргасан гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.13.Хороо хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ хугацаанаас хойш 5 жилийн дотор тухайн гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбар компанийн хөрөнгө оруулагчид, гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал, ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогч, эсхүл тэдгээртэй адилтгах албан тушаал)-д ажиллах этгээдээс тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээн авахгүй.

4.14.Хороо гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбарт тусгай зөвшөөрөл олгосон тухайгаа олон нийтэд мэдээлнэ.

## **ТАВ. Хяналт, хариуцлага**

5.1.Гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбар нь энэ журмаар тавигдсан шаардлагын биелэлтийн тайланг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Хороонд ирүүлнэ.

5.2.Хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбар компанийн дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулж гүйлгээ хийсэн тохиолдолд тухайн гүйлгээг буцааж, Хороо буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.3.Хорооноос энэ журмын биелэлтэд хяналт тавьж гадаадын даатгагч, мэргэжлийн оролцогчийн салбарын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Даатгалын тухай хуулийн 83.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 45.1-д заасны дагуу тус тус хариуцлага хүлээлгэнэ.

## **ЗУРГАА. Бусад зүйл**

6.1.Энэ журмаар зохицуулагдаагүй тусгай зөвшөөрлийн холбогдолтой аливаа асуудлыг Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, даатгалын багц дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

--ooOoo--